



**ХЭНТИЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2022 оны 11 сарын 08 өдөр

Дугаар 6/105

Чингис хот

Т.Тамирыг ажилд томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, 67.4, Төрийн албаны тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1, 27.1.3, 57 дугаар зүйлийн 57.2, 57.2.2 дахь заалт, Засгийн газрын 2019 оны “Төрийн захиргааны албан тушаалын ангилал, зэрэглэл, жагсаалт батлах тухай” 275 дугаар тогтоолын хавсралт, Засгийн газрын 2019 оны “Төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ, хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 472 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт, Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн 2022 оны 96 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Тунгалагын Тамирыг Архивын тасгийн Архивын тоо бүртгэл, сургалт, сурталчилгаа хариуцсан мэргэжилтний албан тушаалд 2022 оны 11 дүгээр сарын 08-аас эхлэн томилсугай.

2.Ажил хүлээлцүүлэх ажлын хэсгийг доорх бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Ажлын хэсгийн

ахлагч: Б.Мөнгөнцэцэг Архивын тасгийн дарга


Гишүүд: Б.Оюунтуяа Архивын тасгийн Сан хөмрөгийн эрхлэгч

Т.Баяртуяа Нярав

3.Т.Тамирын үндсэн цалинг ТЗ-5-1 шатлалаар тогтоон, 642,388 (зургаан зуун дөчин хоёр мянга гурван зуун наян найм) төгрөгөөр тооцож, олгохыг Нягтлан бодогч (Э.Ариунтунгалаг)-д зөвшөөрсүгэй.

4.Архивын тоо бүртгэл, сургалт, сурталчилгаа хариуцсан мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтод заагдсан чиг үүрэг болон хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Т.Тамирт үүрэг болгосугай.

ДАРГА



Ж.ГАНБААТАР